

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 21 өдөр

Дугаар A116

Даланзадгад сум

Орон тооны бус шинжээч
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримт бичгийг хүлээн авах, өргөдлийг хянан үзэх, дүгнэлт гарган ажиллах орон тооны бус шинжээчээр ажиллах мэргэжилтнүүдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримт бичиг болон ажлын байрны үнэлгээг хуульд заасан нөхцөл шаардлагын хүрээнд гаргаж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллахыг орон тооны бус шинжээч нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Б.Цагаанцэнд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

462501124

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн
А/Н/Б дугаар тушаалын хавсралт

ОРОН ТООНЫ БУС ШИНЖЭЭЧЭЭР АЖИЛЛАХ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН НЭРС

Д/д	Мэргэжилтний нэр	Албан тушаал	Орон тооны шинжээчээр ажиллах чиг үүрэг
1.	Б.Ганшагай	Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга	Эмнэлгийн тусламжийн удирдлага зохион байгуулалт хүний нөөцийн хангалт
2.	Б.Амгалан	Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга	Эмнэлгийн тусламж үйлчилгээний удирдлага зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
3.	Б.Батболд	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Эмнэлгийн тусламж үйлчилгээний удирдлага зохион байгуулалт, клиникийн стандарт хангалт
4.	Б.Оюунсүрэн	Хяналт шалгалтын хэлтсийн дарга, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч	Эрүүл мэндийн байгууллагын халдвар хамгаалал
5.	Б.Цагаанцэнд	Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга	Эмнэлгийн тусламжийн удирдлага зохион байгуулалт, анхан шатны бүртгэл мэдээлэл, программ хангамж
6.	Б.Бямбажав	Халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн байгууллагын халдвар хамгаалал
7.	А.Анударь	Халдвар судлаач	Эрүүл мэндийн байгууллагын халдвар хамгаалал
8.	Б.Мөнгөнцэцэг	Орчны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн байгууллагын халдвар хамгаалал
9.	Б.Хатантуул	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан инженер	Эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмжийн хангалт
10.	М.Цэцэгсүрэн	Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах, анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	Эмнэлгийн тусламж үйлчилгээний удирдлага зохион байгуулалт, клиникийн стандарт хангалт
11.	А.Мөнхтуяа	Сувилахуйн тусламж хариуцсан мэргэжилтэн	Сувилахуйн тусламж үйлчилгээ
12.	Д.Сэлэнгэ	Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн	Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах үйл ажиллагаа стандарт хангалт
13.	Б.Мэндбаяр	Эмийн зохистой хэрэглээ, чанар, аюулгүй байдал, хариуцсан мэргэжилтэн	Хүсэлт гаргагчийн баримт бичгийг хүлээн авах, нөхөн бүрдүүлэх, эмийн сан стандарт хангалт
14.	О.Хандармаа	Статистикч их эмч	Анхан шатны бүртгэл мэдээлэл, программ хангамж
15.	О.Номин-Эрдэнэ	БЗДХ/ДОХ, гепатит хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн байгууллагын халдвар хамгаалал